



МОНГОЛЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

БАТЛАВ:
ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН
ТӨВИЙН ДАРГА

..... С.НЯМ-ЭРДЭНЭ

НЭГЖ ДАМЖУУЛАЛТЫН
БОДЛОГО

Боловсруулсан:	Хянаж, өөрчлөлт оруулсан:
	Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
З.Мөнхбат	Ц.Очирхүү

Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр, В корпус,
Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас: (976) 77073689
Цахим хуудас: www.mnas.gov.mn
Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.

ХЭВЛЭСЭН ОГНОО:
11.11.2021

ӨӨРЧЛӨЛТИЙН ДУГААР : 04
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 25.06.2024

АГУУЛГА

Sl.	Бүлэг	Хуудас No.
	Агуулга	2
1	Хамрах хүрээ	3
2	Нэр томъёо тодорхойлолт	3
3	Хэмжлийн үр дүнгийн нэгж дамжуулалтын талаарх бодлого	4
	Өөрчлөлтийн хуудас	5

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc. No: MNAS AP 01	Нэгж дамжуулалтын бодлого	
Issue Date:11.11.2021	Өөрчлөлт No: 04	Хуудас: 2/9
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

НЭГЖ ДАМЖУУЛАЛТЫН БОДЛОГО

MNAS AP01

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү бодлогын баримт бичиг нь хэмжлийн нэгж дамжуулалтыг хэрхэн хангах талаар тайлбарлахад зориулагдсан болно.

Энэхүү баримт бичиг нь туршилтын болон/эсвэл шалгалт тохируулгатай холбоотой ҮИТ-өөр итгэмжлэгдсэн, бүртгүүлсэн бүх ТҮБ(жишээ нь: шалгалт тохируулга болон сорилтын лаборатори, ур чадварын сорилт зохион байгуулагч хяналтын байгууллага, стандартчилсан загвар үйлдвэрлэгчид) -уудад хамаарна.

2. НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Энэхүү баримт бичигт дараахь тодорхойлолтууд хамаарна:

2.1.1 Итгэмжлэгдсэн байгууллага

Энэхүү баримт бичгийн туршид ТҮБ-уудыг багтаасан "Итгэмжлэгдсэн байгууллага" гэсэн нэр томъёог IAC-ийн зохицуулалтад хамаарах байгууллагуудыг нэрлэхэд ашигладаг. Текстэд "Итгэмжлэгдсэн байгууллага" гэсэн нэр томъёог ашиглах бүрт өөрөөр заагаагүй бол энэ нь өргөдөл гаргагч болон Итгэмжлэгдсэн байгууллага хоёуланд нь хамаарна.

2.1.2 BIPM

Олон улсын жин хэмжүүрийн товчоо (Bureau International des Poids et Mesures - BIPM) нь гишүүн орнууд хэмжил зүйн шинжлэх ухаан, хэмжлийн эталонтой холбоотой асуудлаар хамтран ажилладаг Засгийн газар хоорондын байгууллага юм.

2.1.3 ТҮБ Тохирлын үнэлгээний байгууллага

Тохирлын үнэлгээний үйл ажиллагаа явуулдаг, итгэмжлэлийн объект болох байгууллага.

2.1.4 Олон Улсын Жин, Хэмжүүрийн Хорооны Харилцан Хүлээн Зөвшөөрөх Хэлэлцээр (CIPM MRA)

CIPM MRA – Үндэсний хэмжил зүйн хүрээлэнгүүдийн хоорондын хэлэлцээр бөгөөд үндэсний хэмжлийн эталоныг харилцан хүлээн зөвшөөрөх, Үндэсний хэмжил зүйн хүрээлэнгээс гаргасан шалгалт тохируулга, хэмжлийн гэрчилгээний хүчинтэй байдлыг

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc. No: MNAS AP 01	Нэгж дамжуулалтын бодлого	
Issue Date:11.11.2021	Өөрчлөлт No: 04	Хуудас: 3/9
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

хүлээн зөвшөөрөх техникийн тогтолцоог бүрдүүлдэг.

2.1.5 Аттестатчилсан стандартчилсан загвар (CRM)

Хэмжил зүйн хүчин төгөлдөр аргачлалаар нэг буюу хэд хэдэн шинж чанарыг нь тогтоосон утга, түүнтэй холбоотой хэмжлийн эргэлзээ, хэмжил зүйн нэгж дамжуулалтын тухай мэдэгдэлийг агуулсан гэрчилгээ бүхий стандартчилсан загвар (ISO 17034:2016).

2.1.6 Олон улсын жин хэмжүүрийн товчоо (BIPM), Олон улсын клиник хими, эмийн лабораторийн холбоо (IFCC) болон Олон улсын лаборатори итгэмжлэлийн байгууллага (ILAC)-аас хамтран байгуулсан Эмийн Лабораторийн Нэгж Дамжуулалтыг Хангах Нэгдсэн Хороо (JCTLM) нь олон улсад танигдсан, хүлээн зөвшөөрөгдсөн эмийн лабораторийн хэмжлийн ижил тэнцүү байдал, хэмжлийн эталоны нэгж дамжуулалтын талаар сурталчлах, зааварчилгаа өгөх дэлхий нийтийн платформ юм.

2.1.7 Түлхүүр харьцуулалтын өгөгдлийн сан (KCDB)

KCDB нь CIPM MRA-тай холбоотой олон нийтэд нээлттэй, үнэ төлбөргүй цахим сан юм. Үүнд CIPM MRA-д оролцогчдын талаарх мэдээлэл, түлхүүр болон нэмэлт харьцуулалтын үр дүн, шалгалт тохируулга ба хэмжлийн чадавх (CMCs) (<https://www.bipm.org/kcdb>) багтсан болно.

2.1.8 Хэмжил зүйн нэгж дамжуулалт (VIM 3 бүлэг 2.41)

Шалгалт тохируулгын баталгаажсан тасралтгүй гинжин хэлхээний дагуу, үе шат бүрдээ өөр өөрийн эргэлзээний утгыг агуулсан эталонтой харьцуулан гаргаж авсан хэмжлийн үр дүнгийн шинж чанар.

Тайлбар 1: Энэ тодорхойлолтод орсон “эталон”-ыг хэмжлийн нэгжийн тодорхойлолтын практик хэрэгжүүлэлт, эсвэл өвөрмөц бус хэмжигдэхүүний нэгжийг агуулсан хэмжлийн арга, эсвэл хэмжлийн эталон гэж ойлгож болно. ISO/IEC 17025:2017[4] ба ISO 15189:2012[5] нь VIM-ийн "хэмжил зүйн нэгж дамжуулалт" гэсэн нэр томъёог ашигласан.

2.1.9 Хэмжил зүйн нэгж дамжуулалтын хэлхээ (VIM 3 бүлэг 2.42)

Эталон болон хэмжлийн үр дүнгийн хамаарлыг харуулах хэмжлийн эталон ба шалгалт тохируулгын дараалал.

2.1.10 Хэмжлийн нэгжийн хэмжил зүйн нэгж дамжуулалт (VIM 3 бүлэг 2.43)

Хэмжлийн нэгжийг практикт хэрэгжүүлэх замаар гаргаж авсан Практик хэрэглээний дагуу

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc. No: MNAS AP 01	Нэгж дамжуулалтын бодлого	
Issue Date:11.11.2021	Өөрчлөлт No: 04	Хуудас: 4/9
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

тодорхойлсон хэмжлийн нэгжийн тодорхойлолт болдог эталоны хэмжил зүйн нэгж дамжуулалт Хэмжлийн нэгжийг практикт хэрэгжүүлэх замаар гаргаж авсан эталоны нэгж дамжуулалт

Тайлбар: “СИ системийн нэгж дамжуулалт” гэдэг нь “Олон Улсын Нэгжийн системийн хэмжлийн нэгжээс нэгж дамжуулсан” гэсэн утгыг илэрхийлнэ.

2.1.11 Үндэсний хэмжил зүйн хүрээлэн (NMI)

Үндэсний хэмжил зүйн хүрээлэн (NMI) болон томилогдсон мэргэжлийн байгууллагууд (DI) нь дэлхийн өнцөг булан бүрт (эсвэл бүс нутгуудад) хэмжлийн эталоныг бий болгож хадгалдаг. Энэхүү баримт бичигт "NMI" гэсэн нэр томъёог Үндэсний Хэмжил Зүйн Хүрээлэн болон Томилогдсон Мэргэжлийн Байгууллагын аль алинд ашиглана.

2.1.12 Стандартчилсан загвар (RM)

Хэмжлийн үйл ажиллагаанд зориулалтын дагуу ашиглахад тохиромжтой гэж тогтоосон нэг буюу хэд хэдэн шинж чанарын хувьд хангалттай нэгэн төрлийн, тогтвортой материал (ISO 17034:2016).

2.1.13 Стандартчилсан загвар үйлдвэрлэгч (RMP)

Төслийн төлөвлөлт, менежментийг бүрэн хариуцах (байгууллага, компани, төрийн болон хувийн хэвшлийн); Шинж чанарын утгууд болон холбогдох эргэлзээг тогтоох; шинж чанарын утгуудын баталгаа; өөрийн үйлдвэрлэсэн стандартчилсан загварын гэрчилгээ эсвэл бусад мэдэгдлийг олгох байгууллага (ISO 17034:2016).

3. ХЭМЖЛИЙН ҮР ДҮНГИЙН ХЭМЖИЛ ЗҮЙН НЭГЖ ДАМЖУУЛАЛТАД ҮИТ- ИЙН БАРИМТЛАХ БОДЛОГО

ILAC-ын бодлого нь хэмжил зүйн нэгж дамжуулалт шаардлагатай үед хэмжих хэрэгслийг (1) дараах байгууллагуудад шалгалт тохируулга хийлгэсэн байна:

- 1) Олон Улсын Жин Хэмжүүрийн Хорооны Харилцан Хүлээн Зөвшөөрөх Хэлэлцээр(CIPM MRA)-т нэгдсэн, зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулдаг, Үндэсний Хэмжил Зүйн Хүрээлэн (NMI). CIPM MRA-д хамрагдсан үйлчилгээг жагсаасан үйлчилгээ бүрийн СМС-ийг багтаасан Олон улсын товчоо ба хэмжүүрийн гол харьцуулалтын мэдээллийн сангаас (BIPM KCDB) үзэх боломжтой.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc. No: MNAS AP 01	Нэгж дамжуулалтын бодлого	
Issue Date:11.11.2021	Өөрчлөлт No: 04	Хуудас: 5/9
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

Тайлбар 1: Зарим NMI-ууд шалгалт тохируулгын гэрчилгээндээ CIPM MRA логог оруулснаар үйлчилгээгээ CIPM MRA-д хамруулж байгаагаа харуулж болох боловч логог заавал хэрэглэх албагүй бөгөөд BIPM KCDB нь албан ёсны баталгаат эх сурвалж хэвээр байна.

Тайлбар 2: Метрийн конвенцид нэгдэн орсон гишүүн орнуудын NMI нь BIPM дээр хийсэн хэмжилтээс шууд хэмжил зүйн нэгж дамжуулалтыг авч болно. KCDB нь BIPM шалгалт тохируулгын үйлчилгээнд (хүрээ ба эргэлзээг оруулаад) холбогдох автомат холбоосоор хангадаг. BIPM-ээс олгосон бие даасан шалгалт тохируулгын гэрчилгээг мөн жагсаасан болно.

эсвэл

2) Итгэмжлэгдсэн шалгалт тохируулгын лабораторийн үйлчилгээ нь зориулалтын дагуу ашиглахад тохиромжтой (жишээ нь, итгэмжлэлийн хамрах хүрээ нь зохих шалгалт тохируулгыг тусгайлан хамардаг) ба итгэмжлэлийн байгууллага нь ILAC-ийн зохицуулалт эсвэл ILAC-аас хүлээн зөвшөөрсөн бүс нутгийн зохицуулалтад хамрагддаг байна.

Тайлбар 3: Шалгалт тохируулгын лабораторийн итгэмжлэлийн лого бүхий гэрчилгээ эсвэл итгэмжлэгдсэн тухай бичвэр нь ILAC MRA болон түүний бүс нутгийн орнуудад хүлээн зөвшөөрснөөр бүрэн ашиг тусаа өгөх боломжтой. Шалгалт тохируулгын лаборатори нь шалгалт тохируулгын гэрчилгээндээ дараахь зүйлийг оруулснаар үйлчилгээгээ ILAC зохицуулалтад хамруулж байгааг харуулж болно.

- ILAC MRA хосолсон тэмдэг, эсвэл

- Итгэмжлэлийн байгууллага(ILAC зохицуулалтад гарын үсэг зурсан)-ын итгэмжлэлийн тэмдэг эсвэл түүний итгэмжлэлийн статусын тодорхойлолт. Эдгээр хоёр хувилбарыг хэмжил зүйн нэгж дамжуулалтын нотолгоо болгон авч болно (ILAC P8).

эсвэл

3а) Үйлчилгээ нь зориулалтын дагуу явагдаж байгаа боловч CIPM MRA-д нэгдээгүй Үндэсний хэмжил зүйн хүрээлэн(NMI). Энэ тохиолдолд Итгэмжлэлийн байгууллага нь эдгээр үйлчилгээ нь ISO/IEC 17025 стандартад заасан хэмжил зүйн нэгж дамжуулалтын шаардлагыг хангасан эсэхийг баталгаажуулах бодлогыг тогтооно.

эсвэл

3б) Шалгалт тохируулгын үйлчилгээ нь зориулалтын дагуу явагдаж байгаа боловч ILAC-ын зохицуулалт эсвэл ILAC-аас хүлээн зөвшөөрсөн бүс нутгийн зохицуулалтад хамрагдаагүй лаборатори. Энэ тохиолдолд Итгэмжлэлийн байгууллагаас тэдгээр үйлчилгээ нь ISO/IEC 17025 стандартад заасан хэмжил зүйн нэгж дамжуулалтын шаардлагыг хангасан эсэхийг баталгаажуулах бодлогыг тогтооно.

Холбогдох ижил түвшний эсвэл итгэмжлэлийн үнэлгээгээр үнэлэгдсэн дээрх 1) эсвэл 2)-д заасны дагуу шалгалт тохируулгын үйлчилгээгээр хэмжлийн үр дүнгийн нэгж дамжуулалттай болохоо харуулсан итгэмжлэгдсэн байгууллагууд

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc. No: MNAS AP 01	Нэгж дамжуулалтын бодлого	
Issue Date:11.11.2021	Өөрчлөлт No: 04	Хуудас: 6/9
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

Холбогдох ижил түвшний үнэлгээ эсвэл итгэмжлэлд хамрагдсан үйлчилгээ Дээрх 1) эсвэл 2)-ын дагуу санал болгож буй шалгалт тохируулгын үйлчилгээг ашиглан хэмжлийн үр дүнг хэмжилзүйн хянах боломжтой болохыг харуулсан итгэмжлэгдсэн байгууллагууд

3a) эсвэл 3b)-д хамаарах нөхцөл байдалд энэ нь тийм биш тул 1) эсвэл 2) тодорхой шалгалт тохируулга хийх боломжгүй үед л эдгээр зааварыг ашиглах ёстой.

Иймд итгэмжлэгдсэн байгууллагууд хэмжил зүйн нэгж дамжуулалт болон хэмжлийн эргэлзээний талаархи зохих нотлох баримтууд байгаа эсэхийг баталгаажуулах ёстой бөгөөд Итгэмжлэлийн байгууллага эдгээр нотлох баримтыг үнэлнэ.

Стандартчилсан загвар үйлдвэрлэгчдээс (RMPs) аттестатчилсан стандартчилсан загвараар (CRMs) дамжуулан олгодог хэмжил зүйн нэгж дамжуулалтын талаарх ИЛАС-ийн бодлого нь CRM-д олгосон баталгаажуулсан утгын хэмжил зүйн нэгж дамжуулалтыг тогтоохдоо дараах тохиолдолд хүчинтэй гэж үзнэ:

a) BIPM KCDB -д бүртгэгдсэн үйлчилгээгээр Үндэсний хэмжил зүйн хүрээлэнд үйлдвэрлэсэн Аттестатчилсан стандартчилсан загвар.

эсвэл

b) CRM-ийг итгэмжлэлийн хүрээнд итгэмжлэгдсэн СЗҮ үйлдвэрлэдэг бөгөөд Итгэмжлэлийн байгууллага нь ИЛАС-ийн зохицуулалт эсвэл ИЛАС-аас хүлээн зөвшөөрсөн бүс нутгийн зохицуулалтад хамрагддаг бол.

эсвэл

c) CRM-д олгосон аттестатчилсан утгуудыг Эмийн лабораторийн нэгж дамжуулалтыг хангах хамтарсан Хорооны (JCTLM) мэдээллийн сангийн бүртгэлд оруулсан бол.

СЗҮ-ийн итгэмжлэл нь хөгжиж байгаа бөгөөд итгэмжлэгдсэн СЗҮ-д үйлдвэрлэгдсэн CRM олдохгүй байж болохыг хүлээн зөвшөөрч, CRM-ийг итгэмжлэгдээгүй СЗҮ-д үйлдвэрлэсэн бол, итгэмжлэгдсэн байгууллагууд CRM-ийг чадавхтай СЗҮ-ээс хангагдсан, тэдний хэрэглээнд тохирч байгааг нотлон харуулах ёстой.

SI системийн нэгж дамжуулалт нь техникийн хувьд боломжгүй, итгэмжлэгдсэн байгууллага нь дараах үүрэг хүлээнэ:

7a) Эрх бүхий үйлдвэрлэгчээс өгсөн аттестатчилсан стандартчилсан загварын баталгаажуулсан утгыг ашиглан хэмжил зүйн нэгж дамжуулалтын шаардлагыг хангах арга замыг сонгох.

эсвэл

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc. No: MNAS AP 01	Нэгж дамжуулалтын бодлого	
Issue Date:11.11.2021	Өөрчлөлт No: 04	Хуудас: 7/9
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

7b) Тэдний хэрэглээнд тохирсон хэмжлийн үр дүнг өгч байгааг тодорхой тайлбарлаж, хүлээн зөвшөөрсөн жишиг хэмжлийн аргачлал, тусгай арга, эсвэл зөвшилцлийн стандартуудтай харьцуулсан үр дүнгийн баримтжуулалт. Энэхүү харьцуулалтын нотолгоог итгэмжлэлийн байгууллага үнэлнэ.

Тайлбар 4: Зөвхөн хэмжил зүйн нэгж дамжуулалтыг SI системээс авах тохиромжгүй эсвэл ашиглах боломжгүй тохиолдолд нарийн тогтоосон хэмжигдэхүүнийг сонгох хэрэгтэй. Тиймээс хэмжил зүйн нэгж дамжуулалтыг бий болгоход хэмжлийн үр дүнг нотлох баримт болон үр дүнг зохих эталонтой харьцуулсан харьцуулалтын үр дүн зэрэг орно. Харьцуулалт нь хэмжлийн аргачлалыг зохих ёсоор баталгаажуулсан ба/эсвэл нотолгоожуулсан, хэмжих хэрэгслийг зохих ёсоор шалгалт тохируулга хийсэн, хэмжлийн нөхцөл (орчны нөхцөл гэх мэт) нь найдвартай үр дүнг гаргахуйц хангалттай хяналтанд байгааг баталгаажуулах замаар хийгддэг.

Тайлбар 5: Туршилтын дээж материалыг ур чадварын сорилтын (PT) үйлчилгээ үзүүлэгчдээс авах боломжтой. PT үйлчилгээ үзүүлэгч нь туршилтын материалын шинж чанарын үзүүлэлт, матрицын тогтвортой байдлыг харуулах талаар тогтвортой байдлын нэмэлт мэдээлэл өгч чадах эсэхийг шалгах хэрэгтэй. Хэрэв үүнийг өгөх боломжгүй бол эдгээр туршилтын материалыг үр дүнгийн найдвартай байдлыг хангах өөр арга гэж үзэхгүй.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc. No: MNAS AP 01	Нэгж дамжуулалтын бодлого	
Issue Date:11.11.2021	Өөрчлөлт No: 04	Хуудас: 8/9
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Өөрчлөлтийн No	Хуудас No	Өөрчлөлт оруулсан шалтгаан
1	01	04	Шинэчилсэн 2-р хэсэг "...Үйлчилгээ нь зорилтот хэрэгцээнд нийцсэн ба CIPM MRA-д хамаарах Үндэсний хэмжил зүйн хүрээлэн(NMI). CIPM MRA-д хамрагдсан үйлчилгээ тус бүрийн хүрээ, хэмжлийн эргэлзээг агуулсан жагсаалтыг BIPM KCDB-ийн C Хавсралт-аас харж болно..."
2	02	04	2-р хэсэгт "SI нэгжийн хэрэгжүүлэлтийг үндэсний болон олон улсын эталонтой шууд болон шууд бусаар харьцуулах замаар хангах" гэж нэмсэн.
3	03	1	ҮИТ нь шинэ хуулийн этгээд болсон учраас уг баримт бичгийг ҮИТ-өөр батлуулах шаардлагатай болсон. Ийм учраас хянасан болон баталсан хүний нэрийг өөрчилсөн.
4	04	Бүх хуудсанд	ILAC P10:07/2020 баримт бичиг шинэчлэгдсэн холбоотойгоор тус баримт бичигт өөрчлөлт оруулсан.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Doc. No: MNAS AP 01	Нэгж дамжуулалтын бодлого	
Issue Date:11.11.2021	Өөрчлөлт No: 04	Хуудас: 9/9
	Өөрчлөлтийн огноо: 25.06.2024	
ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.		